

Жил бүр зохион байгуулагддаг Уурхайн хаалтын тухай олон улсын хурал нь дэлхийн уул уурхайн үйлдвэрлэл эрхлэгчдийн хувьд чухал арга хэмжээнүүдийн нэг бөгөөд уул уурхайн мэргэжилтнүүдийн хувьд хүсэн хүлээдэг үйл ажиллагаа юм. Уг хуралд оролцогчид уурхайн хаалттай холбоотой олон чиглэлийн асуудлаар санал солилцох, уул уурхайн хөгжил, шинэчлэлийн талаар мэдээлэл авах, тулгамдаж буй асуудлыг анхааран хэлэлцэх талбар болдог. Тус хуралд оролцсоноор та уул уурхайн олон

улсын шилдэг мэргэжилтнүүдийн авч хэрэгжүүлж буй уурхайн хаалтын төлөвлөгөө, технологи процессуудын талаар хамгийн сүүлийн үеийн мэдлэг, туршлагаас суралцах болно.

Мөн хуралд оролцсоноор төрөл бүрийн салбар чиглэлийн олон улсын мэргэжилтнүүдтэй холбоо төгтоох, шинэ харилцаа, сүлжээ үүсгэх, уурхайн хаалтын үйл ажиллагааныг сүүлийн үеийн арга аргачлал, нээлтүүдтэй танилцах боломжтой.

Зохион байгуулагчид



Зохион байгуулалт

◆ Эрдэм шинжилгээний хурал

Илтгэгчид тухайн хурлын сэдвийн дагуу өөрсдийн судалгааны ажлыг олон талт байдлаар, оролцогчдын дунд хэлэлцүүлэг өрнүүлэх хэлбэрээр танилцуулна.

◆ Цахим семинар

Салбарын мэргэжилтнүүд туршлагад суурилсан богино хэмжээний семинарыг хөтлөн явуулна. Уг семинаруудад сүүлийн үеийн судалгаа шинжилгээний үр дүнд гарч буй шинэ санаа, дэвшлүүдийн талаар ярилцах боломж гарах ба ихэвчлэн асуулт, хариулт хэлбэрээр явагддаг.

◆ Үндсэн илтгэлүүд

Дэлхийд хүлээн зөвшөөрөгдсөн салбарын шилдэг мэргэжилтнүүд уурхайн хаалттай холбоотойгоор өөрсдийн үзэл бодлоо хуваалцаж, энэ чиглэлээр гарч буй хөгжил дэвшил болон ирээдүйн хандлагуудын талаар илтгэнэ.

◆ Цахим үзэсгэлэн

Хурлын үеэр цахим болон биет хэлбэрээр үзэсгэлэн гарах ба уг үзэсгэлэн нь уурхайн хаалтын үйл явцтай холбоотой зөвлөх болон бусад төрлийн үйлчилгээ үзүүлэгч байгууллагуудын хувьд бизнесээ таниулах боломж олгоно.

Сэдвүүд

- ◆ Төлөвлөлт: Газрын гадаргын хэлбэржүүлэлт дизайн
- ◆ Орхигдсон уурхай болон үйл ажиллагаа нь зогссон уурхай
- ◆ Үүрэг хариуцлага ба түүнийг хэрэгжүүлэх менежмент
- ◆ Санхүүжилт, зардлын тооцоо
- ◆ Усны менежмент; Хог хаягдлын менежмент
- ◆ Геохими; талбайн нөхөн сэргээлт ба үр нөлөөллийн менежмент

- ◆ Оролцогч талууд болон орон нутгийн иргэд оршин суугчид
- ◆ Экосистем болон орчны нөхөн сэргээлт

Голлох сэдвүүд

- ◆ Хөгжиж буй орнууд дахь уурхайн хаалт
- ◆ Уул уурхай болон болон уурхайн хаалтын явцад учрах 10 бизнесийн эрсдэл
- ◆ Тайгын мөнх цэвдгээс говь цөл хүртэл: ялгаатай экосистемүүд дэх уурхайн хаалт

Хурлын цахим “Эйрмийт” платформд үзэсгэлэн гаргах, ивээн тэтгэх

- ◆ **Ивээн тэтгэгч, үзэсгэлэн гаргагчид илүү үнэ цэн өгнө**
Ивээн тэтгэгч, үзэсгэлэн гаргагчид өөрсдийн цахим талбайгаар зочилсон оролцогчдын тоон мэдээллийг хурлын үйл ажиллагааны дараа авч маркетингийн үйл ажиллагаанд ашиглах боломжтой.
- ◆ **Бодит мэт харилцааг бий болгоно**
Цахим хурлын платформ нь хэлэлцүүлгийн үеэр гар өргөн илтгэгчдээс видео болон бичгэн хэлбэрээр асуулт асуух боломжоор хангасан ба зохион байгуулагч оролцогчдоос санал асуулга авах, зарлал тарааж болно.
- ◆ **Олон хүн оролцоно**
Цахим арга хэмжээ нь газар зүйн хил хязгаарыг үгүй болгож дэлхийн хаанаас ч оролцох боломжоор хангадаг. Энэ жилийн хувьд Уурхайн хаалт 2021 арга хэмжээнд 26 улсын 36 судалгааны материал танилцуулна.


- ◆ **Танилын хүрээг тэлэх боломж**
Цахим арга хэмжээний платформ нь оролцогчдын дунд албан харилцаа үүсгэх бүх л боломжоор хангана. Цаг товлон уулзах, цахим ширээнд хэлэлцүүлэг өрнүүлэх, мессежээр харилцах зэргээр олон улсын оролцогчидтой танилцах боломжтой.
- ◆ **Цахим үзэсгэлэн таны төлөө 24 цагаар ажиллана**
Тус хуралд дэлхийн өнцөг булан бүрээс хүмүүс оролцох ба танай байгууллагын үзэсгэлэн хариуцсан ажилчид байх үгүйгээс үл хамааран хурлын платформ таны байгууллагыг төлөөлөх бүрэн хүчин чадалтай. Татаж авах боломжтой материалууд хавсаргах, видео сурталчилгаа, шууд дамжуулалт, чат, холбоосуудаар цахим танхимаа бүрэн тоноглоорой.



Цахим хэлэлцүүлгийн ширээ нь адил үзэл бодолтой хүмүүстэй танилцах, хүрээллээ тэлэх хамгийн тохиромжтой талбар. Zoom, Google meet зэрэг платформын бүх л функц үүнд бий.

Арга хэмжээний дараа өөрийн байгууллагын цахим үзэсгэлэнтэй **холбоотой тоон мэдээллийг** авч дараа дараагийн маркетингдаа ашиглаж болно.

Цахим үзэсгэлэнгийн танхимаа өөрийн брендийн дагуу тохижуулж, байгууллагаа бусдад сурталчлан, зочилсон хүмүүстэй хэлэлцүүлэг өрнүүлээрэй.



Холбоо барих

Дагдандоржийн Өлзийбаяр
Хурлын менежер

Утас: +976 99058659 (үүрэн)

+976 88119902 (үүрэн)

Ц-шуудан: ulziibayar.d@qmc.mn

mineclosure2021@qmc.mn

Хаяг: Монгол улс, Улаабаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Автозамчдын гудамж 34, “Жэй” оффис